Тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь хичээлийн хөтөлбөрийг судалсан нь

П.Эрдэнэбулган[1], Э.Билгүүн[1], Ш.Батсүх[1], М.Бат-Эрдэнэ[1], Ж.Дэлгэрцэцэг[1]
[1]АШУҮИС-ийн НАСС-ийн НАТЭА-н тэнхим
Цахим шуудан: erdenebulgan@mnums.edu.mn
Утас: 99000310

Түлхүүр үг:
Сургалт, нүүр ам судлал, нүүр амны эрүүл ахуйч, хөгжлийн бэрхшээл

ТОВЧ УТГА

Тусгай хэрэгцээт иргэдийн нүүр амны тусламж, үйлчилгээний эмнэл зүйд тохиолддог саад бэрхшээл, нийгэм, олон нийтийн хандлагыг судалсан олон судалгааны үр дүнд тусгай хэрэгцээт хүмүүсийн талаарх хүн амын мэдлэг мэдээлэл дутмаг, тэдэнд ээлтэй бүтээн байгуулагдсан байгууламж бүхий тусламж үйлчилгээний байгууллага хомс, мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нөөц хангалтгүй байгаа зэрэг нь тусгай хэрэгцээт хүмүүст чиглэсэн бодлого нийгмийн эрүүл мэндийн анхаарлын гадна хаягдахад хүргэж буйг онцолжээ. Үүн дотроос хамгийн чухал нь тусгай хэрэгцээт хүмүүст тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн эмч, мэргэжилтэн бэлтгэх сургалт хэмээн үзжээ. Иймд бусад улсын анагаах ухааны сургуулиудад заагддаг тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, яаралтай болон төлөвлөгөөт эмчилгээ, тусламж үйлчилгээтэй холбоотой сургалтын хөтөлбөрүүдийг судлах, АШУҮИС-ийн НАСС-ийн Шүдний их эмч, Нүүр амны эрүүл ахуйч, Нүүр амны техникч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн өнөөгийн байдалд дүгнэлт хийхийг зорилго болгосон.

Арга аргачлал: Тоон болон чанарын судалгааны загварыг ашиглан, хөтөлбөрийн сургалтын баримт бичгүүд, цахим эх сурвалжийг судалгааны эх материал болгон гүйцэтгэсэн.

Үр дүн: Манай оронд тусгай хэрэгцээт хүмүүст тусламж үйлчилгээ үзүүлэх Нүүр ам судлалын салбарын эмч мэргэжилтнүүд, түүн дундаа нүүр амны эрүүл ахуйч мэргэжилтэн дутагдалтай, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Дүгнэлт: Тусгай хэрэгцээт хүмүүсийн Шүдний их эмч, Нүүр амны эрүүл ахуйч мэргэжилтнүүдийн ажлын байрны орон тоог нэмэх, сургалтын хөтөлбөрийг цогцоор нь шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ҮНДЭСЛЭЛ

Тусгай хэрэгцээт хүмүүс гэдэг ойлголтод төрөлхийн болон олдмол шалтгааны улмаас бие махбод, сэтгэц, мэдрэхүйн их бага хэмжээний алдагдалтай болох, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн, физиологийн ямар нэг үйл хэвийн бус байгаа, өвчин эмгэгийн нөлөөгөөр өдөр тутмын хэвшмэл үйлдлийг гүйцэтгэх чадвараа алдсан, нэмэлт асаргаа сувилгаа шаардлагатай бүхий л насны хүнийг хамааруулдаг. Энэ тухай НҮБ-ын конвенц, Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлд тодорхой заасан байна. Тусгай хэрэгцээ болон хөгжлийн бэрхшээл тухайн хүнд бие махбод, оюун санаа сэтгэхүй, мэдрэхүйн ямар согогоор илэрч байгаатай холбоотойгоор мэдрэхүйн, сэтгэхүйн, хөдөлгөөний, хавсарсан, бусад гэсэн төрөлд ангиллагддаг (Хүснэгт 1).[1]

Хүснэгт 1: Тусгай хэрэгцээт хүмүүс

Тусгай хэрэгцээт хүн	Тодорхойлолт	Илрэл
Биеийн (хөдөлгөөний) бэрхшээлтэй	Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй байдал	Тархи, нугасны гэмтэл, Тархины саажилт, эпилепси, булчингийн дистрофи
Мэдрэхүйн бэрхшээлтэй	Мэдрэхүйн хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдах буюу хязгаарлагдах байдал	Хараа, сонсгол, хэл яриа, үнэрлэх, хүрэлцэхүй, тэнцвэр алдагдлын согог
Оюуны болон сэтгэхүйн бэрхшээлтэй, зан үйлийн асуудалтай	Бодох сэтгэх, ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлттэйн улмаас нийгэмд биеэ авч явах байдал нь хязгаарлагдах байдал	Дауны хам шинж, аутизм, оюуны хомсдол, сэтгэцийн эмгэг, анхаарал сулрах гиперактив эмгэг
Бусад хэлбэрийн бэрхшээлтэй	Ямар нэг физиологийн хэвийн бус байдал болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдах. Тухайлбал: архаг, хүнд өвчин; хавдар, гэмтэл; мэс заслын дараах байдал; ухаангүй байгаа өвчтөн; төрөлхийн гажиг, согогтой хүн; өндөр настан; жирэмсэн эмэгтэй	Зүрх судас, амьсгалын замын болон бусад дотор эрхтний өвчин, чихрийн шижин, цус харвалт, хорт хавдар, ХДХВ/ДОХ-той өвчтөн, мэс заслын дараах байдал, уруул тагнайн сэтэрхий, Алцгеймерийн өвчин, паркинсонизм гэх мэт

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал ICF-д хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамааран тусгай хэрэгцээ шаардагдах түвшин харилцан адилгүй болохыг тодорхой ялган заагласан байдаг.

Тусгай хэрэгцээт хүмүүс нүүр амны тусламж үйлчилгээ авахад тулгарч буй саад бэрхшээлүүд: Амныхөндийнэрүүлмэндньхүнийсайнсайханбайдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг байдаг төдийгүй хүний амьдралын чанарыг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг тул эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар мэдээлэл авах, амны хөндийн эрүүл ахуйг сахих, мэргэжлийн эмчийн үзлэг, эмчилгээнд хамрагдах нь тусгай хэрэгцээт хүмүүсийн хувьд анхаарах асуудал юм. Тусгай хэрэгцээт хүмүүс бусад иргэдийг бодвол нүүр амны болон шүдний өвчлөлд өртөх өндөр эрсдэлтэй байдаг ч эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдах байдал хангалтгүй байна. Энэ нь эмнэлгийн байгууллагууд хүлээн авч үйлчлэхэд хүндрэлтэй байх, шаардлагатай нүүр амны тусламж үйлчилгээ, яаралтай эмчилгээ хийхэд саад их, тусгай хэрэгцээт хүмүүс болон тэдний асран хамгаалагчдын хамтын ажиллагаа, харилцаа холбоо, танин мэдэхүйн чадвар дутмаг байх зэргээс үүдэлтэй байж болно.[2,3] Зарим тусгай хэрэгцээт хүмүүс амьсгалын зам, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчин, чихрийн шижин, цус харвалт, үе мөчний өвчнүүдийн эх уурхай болдог шүд, амны хөндийн өвчлөлд өртсөн байдаг ч, харамсалтай нь эмчлүүлэхгүй явсаар биеийн байдлаа улам хүндрүүлдэг. Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусгай хэрэгцээний талаарх ойлголт, мэдлэг, хандлага, эмнэлзүйн ур чадварын түвшин болон тусгай хэрэгцээт хүмүүст тусламж үзүүлэх туршлага нөлөөтэй байна.[4,5] Тусгай хэрэгцээт хүмүүсийн оюуны болон үйлийн чадамжийн дутагдлын нарийн төвөгтэй байдал нь эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдээс мэдлэг, ур чадвар, туршлага, эерэг хандлагыг илүүтэй шаарддаг.[6] Түүнчлэн тусгай хэрэгцээт хүмүүст зориулсан шүдний эмнэлэг, нүүр амны тусламж үйлчилгээний хүртээмж нийгмийн эрүүл мэндийн асуудал дунд үл

тоомсорлогдох сэдэв болж үлддэгийг олон судлаачид онцолсон байна. Нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүд анхан шатны тусламж үзүүлэх, эмчлэх чадвартай байх ёстой гэсэн байдаг боловч тэдний мэдлэг, ойлголтын дутмаг байдал нь үйлчилгээ үзүүлэхэд саад учруулдагийг тогтоожээ.[7] Тусгай хэрэгцээт хүмүүст тусламж үйлчилгээ үзүүлэхээр мэргэшсэн нүүр ам судлалын салбарын мэргэжилтнүүдийн ялгагдах онцлог нь ердийн шүд, нүүр амны эмнэлэг, эмчилгээнд хамрагдахад бэрхшээлтэй байж болох тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх явдал юм.[1] Тусгай хэрэгцээт хүмүүсийг мэргэшсэн эмч, эмнэлгийн ажилтнууд руу илгээх явцыг хялбар болгохын тулд эрүүл мэндийн салбарын бүх мэргэжилтнүүд тусгай хэрэгцээний хамрах хүрээг ойлгох нь чухал. Ингэснээр тусгай хэрэгцээт хүмүүс эрүүл мэндийн нөхцөл, байдалдаа тохирсон, тэгш, хүртээмжтэй, чанартай нүүр амны тусламж үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх болно. Нэмж дурдахад, тусгай хэрэгцээт хүмүүстэй харилцахад тэдний биеийн ерөнхий байдал, гэр бүлийн байдал, асран хамгаалагчийн хандлага үүрэг, хамтын ажиллагаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Тусгай хэрэгцээ гэж нэрлэгддэг олон янзын нөхцөл байдал нь тусгай хэрэгцээт хүмүүс, тэдний асран хамгаалагч, эмчлэгч эмч, мэргэжилтэнүүдэд харилцаа болон үйлдлийн хүндрэл үүсгэдэг тул тухайн нөхцөлийг хөнгөвчлөх зайлшгүй шаардлагатай хэмээн хэвлэлийн тоймд дурджээ. [8]

Ихэнх судлаачид тусгай хэрэгцээт хүмүүсийн үйлчилгээ, тэдэнд тулгарах саад, бэрхшээлийн талаар судалсан бол цөөн судалгаанд тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр ам судлалын салбарын эмч, мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн талаар тусгасан байна. Тусгай хэрэгцээт хүмүүст зориулагдсан нүүр ам судлалын мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн сургуулийн сургалтын нөөц, санхүү, эдийн засгийн боломж, тухайн орны тусгай хэрэгцээт хүмүүсийн онцлог, нөхцөл байдал болон бусад олон хүчин зүйлс нөлөөлөх ба нийгмийн олон талт оролцоо шаардлагатай. Эмнэлгийн мэргэжилтэн бүр үйлчлүүлэгч тэр дундаа тусгай хэрэгцээт хүмүүстэй зөв харилцах, шуурхай тусламж үйлчилгээ үзүүлэх чадварыг эзэмших нь нэн чухал юм. Чадварлаг эмч, мэргэжилтэн болохын тулд онолын болон эмнэл зүйн мэдлэгийг хангалттай эзэмшсэн байх ёстой боловч оюутнуудын дийлэнх нь (50% - 80%) тусгай хэрэгцээт хүмүүстэй харилцах чадамж дутмаг төдийгүй эмнэлэгийн байгууллагууд мэдрэхүй, оюун ухаан, сэтгэцийн эмгэг, халдварт өвчтэй хүмүүсийг хүлээн авч эмчлэхээс татгалздаг болохыг дурдсан байна.[9] Үүний шалтгаан нь тэднийг удирдан чиглүүлэх сургалт, эмнэл зүйн дадлага туршлага суралцах хугацаанд хангалтгүй байдагтай холбоотой гэж судлаачид дүгнэжээ.[10] Судлаач Dugall A бакалаврын боловсролын сургалтад тусгай хэрэгцээт хүмүүст чиглэсэн сургалтын хөтөлбөрийг бий болгох нь зүйтэй гэсэн байна.[11]

Зорилго: Бид тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь хичээлийн хөтөлбөрийн хэрэгцээ болон агуулгыг харьцуулан судлах зорилго тавьж дараах зорилтуудыг амжилттай хэрэгжүүллээ. Үүнд:

1. Тусгай хэрэгцээт хүмүүст шаардлагатай нүүр амны эмч, нүүр амны эрүүл ахуйч зэрэг мэргэжилтнүүдийн хэрэгцээг тодруулах
2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Анагаах Ухааны боловсрол олгох сургуулиуд дахь тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмчилгээнд туслах хичээлийн хөтөлбөрийн талаар тандах
3. Олон улсын түвшинд тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмчилгээнд туслах сургалтын хөтөлбөрүүдтэй харьцуулах

Арга, аргачлал: Бид энэхүү судалгааг тоон болон чанарын судалгааны загварыг ашиглан, Монгол улс болон олон улсын анагаах ухааны сургуулиудын сургалтад хэрэгжиж буй тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь хичээлийн хөтөлбөртэй агуулгын хувьд дүйцэхүйц сургалтын баримт бичгүүд, цахим эх сурвалжийг ашиглан гүйцэтгэлээ.

Үр дүн: Судалгааны тоймоос үзэхэд тусгай хэрэгцээт болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тархалтыг тооцох үнэлэмж улс бүхэнд өөр бөгөөд хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт, төрөл, үнэлгээ, тооцоход ашигласан аргачлал харилцан адилгүй байдаг байна.[12] Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага дэлхийн хүн амын 15% ямар нэг төрлийн хөгжлийн бэрхшээлтэй, тэдний 80% нь хөгжиж буй орнуудад амьдардаг хэмээн тооцоолжээ.[13] Сүүлийн жилүүдэд тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо өсөж буй нь хүн амын дундаж наслалт нэмэгдэж байгаатай холбоотой. Учир нь нас ахих тусам хүмүүс хөгжлийн бэрхшээлд өртөх эрсдэл илүү өндөр болдог. Мөн дэлхий даяар хүн амын дунд өвчин архагших нөхцөл байдал хавтгайрч, хөгжлийн бэрхшээлтэй хавсрах нь ихсэж байна. Дунд болон доогуур орлоготой оронд амьдарч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 66.5% нь архаг өвчтэй байгааг судлан тогтоожээ.[14] Зарим оронд нийгмийн эрүүл мэндтэй холбоотой нөхцөл байдал,

орчны болон бусад хүчин зүйлс (авто замын осол, байгалийн гамшиг, дайн, хоолны дэглэм зөрчигдөх, мансууруулагч бодист донтох) нь хөгжлийн бэрхшээл үүсэхэд хүчтэй нөлөөлж байна. Монгол Улсын албан ёсны статистикийн үндэсний газрын 2021 оны тайлан мэдээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 106.169 мянгад хүрч өмнөх онтой харьцуулахад 1.3 мянга (1.3%)-аар, 2010 онтой харьцуулахад 24.4 мянга (29.6)-аар нэмэгджээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 20-34 насныхан 21.7 мянга (20.2%), 35-64 насныхан 64.4 мянга (61.1%) байгаа бөгөөд насны бүлэг ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо (65 ба түүнээс дээш насыг оруулахгүйгээр) нэмэгдэж, талаас илүү хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Зөвхөн хөдөлгөөний бэрхшээлтэй хүний тоо 2021 оны байдлаар улсын хэмжээгээр 21011 (12544 эрэгтэй, 8467 эмэгтэй) байна.

Тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны тусламж үйлчилгээ: Хөгжсөн улс орнууд тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны нарийн мэргэшлийн мэргэжилтнийг тусгай сургалтын хөтөлбөрийн дагуу бэлддэг. 1981 онд Америкийн шүдний эмч нарын холбоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шүдний эмч нарын академи хамтран “Тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмч” сэтгүүлийн суурийг тавьснаар “тусгай хэрэгцээ” гэсэн нэр томъёо гарч ирсэн.[1] Их Британид тусгай хэрэгцээт хүмүүсийн шүдний эмч гэдэг нь «бие махбод болон сэтгэцийн бэрхшээлтэй өвчтөнүүдэд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг шүдний эмчийн мэргэшил» гэж тодорхойлсон.[15] Австрали болон Шинэ Зеландад тусгай хэрэгцээт хүмүүст үйлчилдэг нүүр амны эмчилгээний салбартай бөгөөд «бие махбод болон сэтгэцийн эмгэгийн улмаас нэмэлт асаргаа шаардлагатай хүмүүсийн амны хөндийн эрүүл мэндийн асуудалтай холбоотой нүүр амны эмчилгээ» гэж тодорхойлдог.[16] Япон улсад 1955 он хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шүдний эмчилгээ, үйлчилгээг хувийн эмнэлэгт ажилладаг эмч нар сайн дурын үйл ажиллагааны үндсэн дээр үзүүлдэг байсан. 1960-аад оноос нүүр амны их эмч нарын нэгдсэн холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нүүр амны эмчилгээний тусламж үзүүлэх системийг зохион байгуулж, тэдэнд зориулсан эмчилгээний төвүүдийг байгуулсан бөгөөд орчин үед бүх насныханд чиглэсэн эмчилгээний менежмент нэвтрүүлэн ажиллаж байна.[17] 2016 онд Малайз улсын шүдний мэргэжилтнүүдийн зөвлөл тусгай хэрэгцээт хүмүүсийн шүдний эмнэлэг, шүдний эмч, хэмээх нэр томъёог баталсан бөгөөд “бие махбод, оюуны эмгэгтэй хүмүүсийн амны хөндийн эрүүл мэндийн менежменттэй холбоотой шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ нь нарийн төвөгтэй учраас шаардлагад нийцсэн тусгай техник, арга хэрэглэх шаардлагатай болдог гэж үзжээ.[18] Манай орны улсын болон хувийн хэвшлийн аль ч эмнэлэгт нүүр амны эрүүл ахуйч болон мэргэшсэн мэргэжилтэн өнөөдрийн байдлаар ажиллаагүй байна.

Тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны тусламж үйлчилгээний хүртээмж: Бусад орнуудын жишгээр нүүр амны эмч нарын ур чадвараас хэтэрсэн тохиолдолд тусгай хэрэгцээт хүмүүсийн эмч, мэргэжилтнүүд рүү шилжүүлэн эмчилгээг үргэлжлүүлэх замаар энэ бүлгийн хүмүүст анхаарал хандуулах шаардлагатай байна.[1] Иймээс манай улсад шүдний тусгай эмчилгээ шаардлагатай өвчтөнүүдэд чиглэсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, сайжруулах, өөрчлөх шаардлага гарч буй юм. Судалгаанаас үзэхэд АНУ-д тусгай хэрэгцээт хүүхдийн шүдний эмч, мэргэжилтнүүд үйл ажиллагаа явуулдаг.[19] Их Британид хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй өвчтөнүүдийг тусгай хэрэгцээт хүмүүсийн нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтнүүд эмчилдэг. Австралид тусгай хэрэгцээт өвчтөнүүдэд үзүүлэх үйлчилгээ сайн бөгөөд бүс нутаг тус бүрд эмнэлэг байдаг.[20] Малайз улсад тусгай хэрэгцээт хүмүүст ээлтэй байр, эмнэлэг, боловсон хүчний нөөц дутмаг гэж үздэг тул хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төвүүдийг байгуулж байна.[21] Малайз улсын туршлагаас харахад анагаах ухааны сургуулийн гуравдугаар дамжааны оюутнууд тусгай хэрэгцээт хүмүүстэй холбогдол бүхий семинарт түлхүү оролцож мэдлэгээ тэлдэг бол; дөрөв, тавдугаар дамжааны оюутнууд өндөр настны асрамжийн газар болон нөхөн сэргээх төв зэрэгт ажиллан, тусгай хэрэгцээт хүмүүст үзлэг, оношилгоо хийн, эмчилгээний төлөвлөгөөг бэлдэхэд оролцдог.[21] Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй анагаах ухааны сургуулиудын тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмчилгээнд туслах хичээлийн хөтөлбөрийн талаар тандахад зөвхөн Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Нүүр Ам Судлалын Сургууль «Хөгжлийн бэрхшээлтэй хүний нүүр амны өвчний эмчилгээнд туслах нь» 2 багц цагийн хичээлийг 2009 оноос Нүүр амны эрүүл ахуйн дипломын сургалтын хөтөлбөрт, 2016 оноос 1 багц цагийн хичээлийг Шүдний их эмч бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөрт оруулсан байна. Одоогийн байдлаар сургалтын хөтөлбөр зорилго, заах арга зүй, үнэлгээний хувьд дутагдалтай, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр тус бүрт чиглэсэн үйлдлийн удирдамж байхгүй байна. Тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмчилгээ, урьдчилан сэргийлэлт хичээлийг сургалтын хөтөлбөртөө хэрэгжүүлсэн Их

Британи, АНУ, Япон, Солонгос, Хонг Конг, Австрали, Малайз зэрэг улсын анагаах ухааны сургуулиудын хөтөлбөрийг АШУҮИС-ийн НАСС-ийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсныг үзүүлэв (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Олон улсын АУ-ы сургуулиудын тусгай хэрэгцээт хүмүүст чиглэсэн нүүр амны тусламж хичээлийн сургалтын хөтөлбөрийн харьцуулалт

Улс	Хөтөлбөрийн хамрах хүрээ	Сургалтын цаг	Судлах хэлбэр	Сургалт явагдах байршил	ТХХ-т зориулсан тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх	Тулгамдсан асуудал
Австрали	Их, дээд сургуулиудын 75%	2 -34	Лекц, эмнэл зүйн дадлага	Шүдний сургууль болон эмнэлэг, асрамжийн газар, тусгай дунд сургууль	Өргөгч, шилжүүлэх тэргэнцэр, зөөврийн шүдний сандал тайвшруулах, ерөнхий мэдээ алдуулалт хийх хэсэгтэй	-Сургалтын хөтөлбөр хэт ачаалалтай -ТХХ-ий эмч, мэргэжилтэн дутагдалтай
Япон	Бүх их, дээд сургуулиуд	19 - 69	Лекц, эмнэл зүйн дадлага, семинар	Нэгдсэн болон шүдний эмнэлэг, сэргээн засах төв, асрамжийн газар	Ерөнхий мэдээ алдуулалт хийх хэсэгтэй	-Сургалтын хэлбэр хязгаарлагдмал
Солонгос	Нарийн мэргэшлийн сургалт			Нэгдсэн болон шүдний эмнэлэг, сэргээн засах төв, асрамжийн газар	Ерөнхий мэдээ алдуулалт хийх хэсэгтэй	Зөвхөн ажиглалт хийдэг.
Малайз	Их, дээд сургуулиудын 15%	6 - 27	Лекц, эмнэл зүйн дадлага, семинар, бүлгийн хэлэлцүүлэг	Шүдний сургууль болон эмнэлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр өнжүүлэх, сэргээн засах төв	Шилжүүлэх тэргэнцэр, зөөврийн шүдний сандал тайвшруулах, ерөнхий мэдээ алдуулалт хийх хэсэгтэй	-ТХХ-ий эмч, мэргэжилтэн болон барилга байгууламж дутагдалтай
Англи	Их, дээд сургуулиуд	2О удаа лекц 3 удаа семинар	Лекц, семинар, тохиолдолд суурилсан сургалт, жижиг бүлгүүдийн туршилт	Шүдний сургууль болон эмнэлэг, асрамжийн газар, тусгай дунд сургууль	Өргөгч, шилжүүлэх тэргэнцэр, зөөврийн шүдний сандал тайвшруулах, ерөнхий мэдээ алдуулалт хийх хэсэгтэй	-Сургалт явуулах, ур чадварын хувьд туршлага дутмаг
Монгол	АШУҮИС, НАСС	2 багц цаг	Лекц, эмнэл зүйн дадлага	НАСС	хангагдаагүй	Бүх хүчин зүйлс дутагдалтай

Хэлцэмж:

Дэлхийн бусад орны нэгэн адил Монгол улсад нүүр ам судлалын салбарын мэргэжилтнүүд тусгай хэрэгцээт хүмүүсийг эмчлэх бэрхшээлтэй тулгарч байна. Эрүүл хүмүүстэй харьцуулахад тэдэнд шүдний эмчилгээ хийх, шүд, эрүү нүүрний цаашдын төлөв байдлыг хянахад хүндрэлтэй, халдварт өртөх эрсдэлтэй зэрэг хүрээлэн буй орчны талаас тулгамдах олон асуудал урган гарч байдаг.[2] Манай улсад тусгай хэрэгцээт хүмүүсийн амны хөндийн эрүүл ахуйн боловсролд онцгой ач холбогдол өгдөггүй, тэр байтугай зарим сургуулиудад тусгай хэрэгцээт хүмүүс рүү чиглэсэн сургалтын хөтөлбөр байдаггүйн улмаас тэдэнтэй харилцахад тулгарч буй бэрхшээлийг даван туулах нь нүүр ам судлалын салбарын мэргэжилтнүүдийн хувьд асуудал болж байна. Суралцагчдад зориулсан тусгай хэрэгцээт хүмүүс рүү чиглэсэн сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөө хангалтгүй байгаа нь ганц бэрхшээл бус бөгөөд мэргэшсэн багш, сургалтын материал хомс, зориулалтын тоноглол бүхий шүдний тоног төхөөрөмж дутагдалтай зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлж байна. Австрали, Малайз зэрэг орны эмч мэргэжилтнүүдийн дийлэнх нь сургуулийн удирдлагын тусгай хэрэгцээт хүмүүсийн талаарх мэдлэг дутмаг байдал нь сургалт явуулахад тулгарч буй гол бэрхшээл гэж тодорхойлсон. Мөн судалгаанд оролцогчид «хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй байгууламж» дутмаг байгааг онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ нь тусгай хэрэгцээт хүмүүст

боловсрол олгоход саад тотгор учруулдаг.[20] Үүнээс гадна шүдний эмч, мэргэжилтэн бэлддэг сургуулиуд тусгай хэрэгцээт хүмүүс рүү чиглэсэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, боловсронгуй болгох шаардлагатай, тухайн сургалтын хөтөлбөрийг ашиглан хичээл заах нь нийгэмд ч үр өгөөжөө өгөх болно хэмээн үзжээ. Америкийн шүдний мэргэжилтнүүдийн нийгэмлэг үндсэн ур чадварыг сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгон нэгтгэснээр зөвхөн тусгай хэрэгцээт хүмүүс төдийгүй бусад бүх өвчтөнүүдэд хүртээмжтэй байх болно гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.[22] Нүүр амны эмч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа төрийн бодлого, хууль журам, тухайн орон нутгийн хэрэгцээ шаардлагыг тусгах, зорилтот хүн амдаа тохирсон байдлыг харгалзах нь чухал. Тусгай хэрэгцээт хүмүүс рүү чиглэсэн нүүр амны тусламж, үйлчилгээний стандартчилсан сургалтын хөтөлбөрийг цогцоор нь боловсруулах нь тэдэнд үйлчлэх нүүр амны салбарын ажлыг сайжруулах гол түлхүүр болох нь тодорхой байна. Хөтөлбөр боловсруулагчид, оролцогч талууд гар нийлэн ажиллах ёстой. [22] Тусгай хэрэгцээт хүмүүсийн амны хөндийн эрүүл мэндийн хяналтыг сайжруулахын тулд шүдний эмчилгээний асуудал, урьдчилан сэргийлэх арга зам, асран хамгаалагчидын хариуцлагын тогтолцоог цогцоор нь шийдвэрлэх чадварлаг мэргэжилтнүүдийг сургахад чиглэсэн хөтөлбөрийг боловсруулах нь үр дүнд хүрэхийн чухлыг ойлгох ёстой.[23]

Дүгнэлт:

1. Манай улсын тусгай хэрэгцээт хүмүүсийн тоо хэмжээтэй харьцуулахад нүүр ам судлалын мэргэшсэн эмч, эрүүл ахуйч, мэргэжилтнүүдийн хэрэгцээ, шаардлага их байна. Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд тусгай хэрэгцээт хүмүүст үйлчлэх нүүр амны мэргэшсэн эмч, нүүр амны эрүүл ахуйч мэргэжилтэний орон тоо байхгүй байна.
2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй анагаах ухааны сургуулиудын тусгай хэрэгцээт хүмүүсийн нүүр амны эмчилгээнд туслах хичээлийн хөтөлбөрийн талаар тандахад АШУҮИС-ийн НАСС-иас бусад сургуулиудад уг хөтөлбөр хэрэгждэггүй.
3. Англи, Австрали, АНУ, Япон, Солонгос, Малайз зэрэг улсуудын анагаах ухааны сургуулиудад уг хичээлийн хөтөлбөр ордог бөгөөд сургалтын орчин, нөхцөл, байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан, Засгийн газрын бодлогод нь нарийн тусгагдсан байдаг байна.

НОМ ЗҮЙ:

1. *Mohamed Rohani M, Calache H, Borromeo GL. Referral patterns of special needs patients at the Royal Dental Hospital of Melbourne, Victoria, Australia. Aust Dent J 2017;62:173-179.*
2. *Loster BW, Likeman PR. Teaching of dentistry to medical students in English at the Jagiellonian University, Krakow, Poland. Eur J Dent Educ 2012;16:e1-2.*
3. *Bonwell PB, Parsons PL, Best AM, Hise S. An interprofessional educational approach to oral health care in the geriatric population. Gerontol Geriatr Educ 2014;35:182-99.*
4. *Грамменос С. Өвчин, хөгжлийн бэрхшээл ба нийгмийн хамрагдалт. дублин, Амьрах болон ажиллах нөхцлийг сайжруулах Европын Сан, 2003 он (http://www.eurofound. europa.eu/pub-docs/2003/35/en/1/ef0335en.pdf*
5. *Cumella S, Ransford N, Lyons J, Burnham H. Needs for oral care among people with intellectual disability not in contact with community dental services. J Intellect Disabil Res 2000;44:45-52.*
6. *Pezzementi ML, Fisher MA. Oral health status of people with intellectual disabilities in the southeastern United States. J Am Dent Assoc 2005;136:903-12.*
7. *Paley GA, Slack-Smith L, O’Grady M. Oral health care issues in aged care facilities in western Australia: Resident and family caregiver views. Gerodontology 2009;26:97-104.*
8. *Tsai W-CW, Kung P-TP, Chiang H-HH, Chang W-CW. Changes and factors associated with dentists’ willingness to treat patients with severe disabilities. Health Policy 2007;83:363-74*
9. *Joint Advisory Committee for Special Care Dentistry (JACSCD). A Case for Need: Proposal for a Specialty in Special Care Dentistry. London, UK: JACSCD; 2003.*
10. *Chol-O Han. Social Development Division, Disability statistics in the ESCAP region: An overview – A review of available statistics on, presented in United Nations Regional Meeting on Disability Measurement and Statistics in support of the 2030 Agenda for Sustainable Development and the 2020 World Population and Housing Census Programme, 26-28 July 2016, UNCC, Bangkok URL: https://unstats.un.org/unsd/demographic-social/ Naimie, et al.: Curriculum for Special Care Dentistry Journal of International Oral Health ¦ Volume 12 ¦ Issue 1 ¦ January-February 2020 7 meetings/2016/bangkok--disability-measurement-and-statistics/ Session-3/ESCAP-1.pdf (Last accessed 23 Sep. 2019).*
11. *Joint Advisory Committee for Special Care Dentistry (JACSCD). A Case for Need: Proposal for a Specialty in Special Care Dentistry. London, UK: JACSCD; 2003.*
12. *ADA. Policy Statement 2.4. Specialisation in Dentistry. New South Wales, Australia: Australian Dental Association; 2008. p. 1-4.*
13. *Morito A. Хүүхдийн нүүр ам судлал. Япон: Ishiyaku publishers Inc, 2007.*
14. *Malaysia Pro-Tem Dental Specialty Board (DSB) Meeting, October 11, 2016, Klang, Selangor. Unpublished Report, 2016.*

15. *Mohamed Rohani M, Calache H, Borromeo GL. Referral patterns of special needs patients at the Royal Dental Hospital of Melbourne,Victoria, Australia. Aust Dent J 2017;62:173-179.*
16. *ADA. Policy Statement 2.4. Specialisation in Dentistry. New South Wales, Australia: Australian Dental Association; 2008. p. 1-4.*
17. *Ahmad MS, Razak IA, Borromeo GL. Special Needs Dentistry: Perception, attitudes and educational experience of Malaysian dental students. Eur J Dent Educ 2015;19:44-52.*
18. *Holder M, Waldman HB, Hood H. Preparing health professionals to provide care to individuals with disabilities. Int J Oral Sci 2009;1:66-71.*
19. *Dougall A, Pani SC, Thompson S, Faulks D, Romer M, Nunn J. Developing an undergraduate curriculum in Special Care Dentistry—By consensus. Eur J Dent Educ 2013;17:46-56.*
20. *Pezzementi ML, Fisher MA. Oral health status of people with intellectual disabilities in the southeastern United States. J Am Dent Assoc 2005;136:903-1.*
21. *Cowpe J, Plasschaert A, Harzer W, Vinkka-Puhakka H, Walmsley AD Profile and competences for the graduating European dentist—Update 2009. Eur J Dent Educ 2010;14:193-20.*
22. *American Dental Association. 2007. Accreditation standards for advanced education programs in general practice residency. Commission on Dental Accreditation. Available at: https://www.ada.org/~/media/CODA/files/gpr.pdf ?la=en. [Last accessed on 22Sep. 2019].*
23. *Natrah AF, Jacob J, Wen Thong K, Shani AM, Wan-Lin Sarah L, CheeSoonW, et al. Special care dentistry curriculumat undergraduate level: Students’ perspective. J Dent Indonesia 2015;22:75-79.*

STUDY OF “ASSISTANCE IN THE TREATMENT OF FACIAL AND ORAL DISEASES OF PEOPLE WITH SPECIAL NEEDS” CURRICULUM

Erdenebulgan P[1], Bilguun.E[1], Batsukh Sh[1], Bat-Erdene M[1], Delgertsetseg G[1].
[1]Department of Dental Technology and Oral Hygiene, School of Dentistry, Mongolian National University of Medical Sciences.
e-mail: erdenebulgan@mnums.edu.mn
phone: 99000310

Keywords:
Curriculum, Dentistry, Special Needs, Disability

ABSTRACT

Many researchers who have studied the barriers and social attitudes of people with special needs in the practice of oral care and services have found that the lack of public knowledge about people with special needs, the lack of facilities that are friendly to people with disabilities, and the insufficient resources of doctors and medical specialists will leave the policy for people with special needs out of the spotlight. Highlighted the factors, and the most important was the training to prepare doctors and specialists for people with special needs. A review by other researchers has also shown differences in teaching methods, with most countries developing their own specific curricula in studies of special needs oral care curriculum taught in international medical schools. Designing and implementing effective and socially responsive curriculum for people with special needs is a challenge. Therefore, it was considered as a review in order to evaluate the current status of the programs of School of Dentistry, Mongolian National University of Medical Sciences to compare them with training related to the prevention and treatment of oral diseases aimed at people with special needs in other countries, and to eliminate the differences in the curriculum.

МОНГОЛ АНАГААХ УХААНЫ
ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ
Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
1942

ЭРДМИЙН ЧУУЛГАН 65

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ САЛБАР ХУРАЛДААН

